

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө хаягт байрлах "Номин юнайтед" төвийн 4.5 дугаар давхрын "Улаанбаатар" хурлын танхимд биечлэн болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах.
 - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нөхөн болон улируулан сонгох.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2024 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор дамжуулан тараахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн болон цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг хурал эхлэх хүртэл хугацаагаар тасалбар болгож, брокер дилерийн

компаниуд болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах "Номин юнайтед" цогцолборын 4-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр тус тус хүлээж авахаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Навааныг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Ганзоригийн Өсөхбаярыг, тооллогын комиссын гишүүдээр Хуульч Чулуунбаатарын Нарангэрэл, Нягтлан бодогч Нямбаатарын Сүрэнжав нарыг томилсугай.
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатарыг, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

2025 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

№: 25/06

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хурлын
шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралтаар дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

“Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны өдрийн
25/06 дугаартай тогтоолын Хавсралт



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
 - 1.1. ОРЛОГО: Компани 2024 онд түрээсийн үйл ажиллагаанаас 8,638,785,569.00 төгрөгийн орлоготой ажилласан.
 - 1.2. ЗАРДАЛ: Компани 2024 онд үндсэн үйл ажиллагаандаа 7,699,032,854.31 төгрөгийн зардалтай ажилласан.
 - 1.3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: Компани дээрх орлого болон зардалд үндэслэн 2024 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 939,752,714.69 төгрөгийн ашиг олсон байна.
2. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:
 - 2.1. БУСАД ОРЛОГО: Компани 2024 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01-р сарын 13-ны өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн 210/МА2023/00845 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2023 оны 07-р сарын 04-ний өдрийн шүүх хуралдааны 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу хариуцагч нараас 2,400,000,000 төгрөгийн орлого хүлээн авсан.
 - 2.2. БУСАД ЗАРДАЛ: Компани 2024 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн хуралдааны 517 дугаартай тогтоолын дагуу бусдад 4,263,715,414.00 төгрөгийн хохирлын төлбөр төлсөн.
 - 2.2. БУСАД АШИГ, АЛДАГДАЛ: Компани 2024 онд үндсэн бус үйл ажиллагааны 3,080,935.53 төгрөгийн ашигтай, хойшлогдсон татварын тооцоо 18,609,245.93 төгрөг, нийт 3,361,442,896.15 төгрөгийн ашигтай ажилласан байна.
3. ЦЭВЭР АШИГ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2024 онд 3,420,191.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлээр 3,361,442.9 сая төгрөгийн ашигтай ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 98.3% байна.
4. ДҮГНЭЛТ: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг хангалттай гэж дүгнэв.